



ЯПОН УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Үндсэн хуулийн эрх зүйн маргаан¹)

ТРАНСЖЕНДЕР ХҮН ХҮЙСЭЭ ХУУЛЬ ЁСООР ӨӨРЧЛӨХӨД НӨХӨН ҮРЖИХҮЙН ЧАДВАРГҮЙ БОЛГОХ МЭС ЗАСАЛ ХИЙЛГЭХИЙГ ШААРДАХ НЬ ҮНДСЭН ХУУЛЬД НИЙЦЭХГҮЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: Reiwa 2 (Ku) №993

Шүүхийн шийдвэрийн огноо: 2023 оны 10 дугаар сарын 25-ний өдөр

Шийдвэрийн төлөв: Трансжендер хүний хүйсийн байдлыг зохицуулах тухай хуулийн 3.1.4 дэх хэсэгт заасан зохицуулалт нь Үндсэн хуулийн Арван гуравдугаар зүйлд харшилсан гэж үзэв.

МАРГААНЫ ТУХАЙ ТОВЧ

Трансжендер² эрэгтэй А нөхөн үржих чадваргүй болгох мэс засал (яп. 生殖腺除去手術) хийлгүүлэхгүйгээр хүйсийн хувьд өөрийгөө эмэгтэй болгохыг тогтоолгох агуулгатай хүсэлтийг Гэр бүлийн шүүхэд гаргасан боловч, Трансжендер хүний хүйсийн байдлыг зохицуулах тухай хууль (2003)³ -ийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх хэсэг “нөхөн үржихүйн чадваргүй байх”⁴ болон 3.1.5 дэх хэсэг “гадаад байдлын хувьд солигдох хүйстэй төстэй болсон байх” хэмээх шаардлагуудыг хангаагүй гэж үзэж шүүх хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан. Энэхүү захирамжийн үндэслэл болсон дээрх хуулийн зохицуулалтууд нь Үндсэн хууль (1946)-ийн Арван гуравдугаар зүйл⁵, Арван дөрөвдүгээр зүйлд⁶ тус тус харшилсан хэмээн үзэж А нь Улсын дээд шүүхэд гомдол гаргажээ.

¹ 最高裁令和5年10月25日大法廷決定

Decision of the Supreme Court, Reiwa 5・10・25

<https://www.courts.go.jp/assets/hanrei/hanrei-pdf-92527.pdf>

² Трансжендер гэдэг нь сэтгэл зүйн хувьд биологийн хүйсээсээ өөрөөр ойлгож, мэдрэх хүйсийн баримжааг хэлнэ.

³ 性同一性障害者の性別の取扱いの特例に関する法律 (2003 年)

<https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/2542> 2026 年 6 月 16 日最終閲覧)。

Seidōitsusei shōgaisha no seibetsu no toriatsukai no tokurei ni kansuru hōritsu (2003).

⁴ 3 дугаар зүйлийн 3.1.4.

“Нөхөн үржихүйн булчирхай байхгүй байх, эсхүл нөхөн үржихүйн үйл ажиллагаа нь нөхөн сэргээх боломжгүйгээр алдагдсан байх.”

⁵ Арван гуравдугаар зүйл. Хувь хүнийг хүндэтгэх, нийтийн сайн сайхан байдал

“Бүх иргэд хувь хүнийхээ хувьд хүндлэгдэх ёстой. Амьдрах, эрх чөлөө болон аз жаргалыг эрэлхийлэх эрх нь нийтийн сайн сайхан байдалд харшлахгүй бол хууль тогтоох болон бусад төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ тэдгээрийг дээд зэргээр хүндэтгэн үзэх шаардлагатай.”

⁶ Арван дөрөвдүгээр зүйл. Тэгш байдал...

“Бүх иргэд хуулийн өмнө эрх тэгш бөгөөд арьсны өнгө, итгэл үнэмшил, хүйс, нийгмийн байдал эсвэл үндэс угсаагаар нь улс төр, эдийн засаг, эсхүл нийгмийн харилцаанд ялгаварлан гадуурхаж үл болно.”



ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Улсын дээд шүүх гомдлыг хүлээн авч нийт шүүгчдийн хуралдаанаар маргаан бүхий хуулийн зохицуулалтууд Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянан хэлэлцэж дараах шийдвэрийг гаргасан.

Маргаан бүхий хууль нь трансжендер хүнд өөрийгөө ямар хүйстэй болохыг тогтоолгох боломжийг олгодог. Трансжендер хүн уг хууль ёсны ашиг сонирхлоо хэрэгжүүлэхийн тулд нөхөн үржихүйн чадваргүй болгох мэс засалд орох шаардлагатай болдог. Энэ нь Үндсэн хуулийн 13 дугаар зүйлээр хамгаалагдсан *“өөрийн хүсэл зоригийн эсрэг чиглэсэн бие махбодын халдашгүй байдалд халдах явдлаас ангид байх эрх чөлөө”*-г хязгаарласан явдал юм.

Өөрөөр хэлбэл хуульд заасан ашиг сонирхлоо хэрэгжүүлэхийн тулд нөхөн үржих чадваргүй болгох мэс засалд орох, эсхүл хууль ёсны ашиг сонирхлоо хэрэгжүүлэхээс татгалзах сонголтыг үүсгэж байгаа нь хүний эрхийг зохих түвшинд хязгаарлах хэмжээнээс хэтэрсэн гэж үзжээ. Нөгөөтээгүүр, тус хуулийг батлах үед хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахыг зөвтгөж байсан нөхцөл байдал өөрчлөгдсөн байна. Тухайлбал, сүүлийн үеийн анагаах ухааны хөгжлийн үр дүнд заавал нөхөн үржихүйн чадваргүй болгох мэс засалд орох шаардлагагүй болсон.

Дээрх үндэслэлээр, Трансжендер хүний хүйсийн байдлыг зохицуулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх хэсэгт заасан заалт нь Үндсэн хуулийн 13 дугаар зүйлийг зөрчсөн гэж үзжээ. Харин 3.1.5 дахь хэсэгт заасан зохицуулалт нь Үндсэн хууль зөрчсөн эсэхэд дүгнэлт өгөлгүйгээр давж заалдах шатны шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаасан.